Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ СҮРЭНЖАВЫН ЭНХЖИНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого, хууль тогтоомжийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаа** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1. "Эрүүл идэвхтэй амьдрал 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээ хийх | Үнэлгээний тайлан | - | Үнэлгээний тайлан | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/780 дугаар тушаалаар баталсан "Эрүүл, идэвхтэй амьдрал" 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээ хийж, тайлан боловсруулсан. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 42.1%, шалгуур үзүүлэлтийн биелэлт 45.8%-тай байна. Үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлийн 2025.04.24-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Хурлын шийдвэрийг Дотоод меморандум №138-аар НЭМБГ, ЭТБГ, СТГ-ын дарга нарт, үнэлгээний тайланг 8/2190 дугаар албан бичгээр ЭМЯ-ны харьяа ЭМБ, аймаг, нийслэлийн ЭМГ-ын дарга нарт тус тус хүргүүлсэн. | 2025.03-04 дүгээр сар | **100.0** |
| 2 | Арга хэмжээ 1.2. "Орчны эрүүл мэнд" хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх арга | Үнэлгээний тайлан | - | Үнэлгээний тайлан | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/349 дүгээр тушаалаар баталсан "Орчны эрүүл мэнд" хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд үр нөлөөний | 2025.05-06 дугаар сар | **100.0** |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээ хийх | | | | үнэлгээ хийж, тайлан боловсруулсан. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 59.9%, шалгуур үзүүлэлтийн биелэлт 40.7%-тай байна. Үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлийн 2025.06.19-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, тайланг Дотоод меморандум №... газар, хэлтсийн дарга нарт, 8/.... албан бичгээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. | | |
| 3 | Арга хэмжээ 1.3. "Эрүүл, чийрэг эр хүн" арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээ хийх | Үнэлгээний тайлан | - | Үнэлгээний тайлан | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/559 дүгээр тушаалаар баталсан "Эрүүл, чийрэг эр хүн" арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээ хийж, тайлан боловсруулсан. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 49.6%, шалгуур үзүүлэлтийн биелэлт 39.3%-тай байна. Үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлийн 2025.05.29-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Үнэлгээний тайланг 8/2894 дүгээр албан бичгээр ЭМЯ-ны харьяа эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн ЭМГ-ын дарга нарт тус тус хүргүүлсэн. | 2025.04-05 дугаар сар | **100.0** |
| **Зорилт 2. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаа** | | | | | | | |
| 4 | Арга хэмжээ 2.2. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны | ЭМЯ болон дээд шатны байгууллагын үнэлгээний | Жил бүр үнэлгээ хийж, тайланг ЗГХХГ-т хүргүүлдэг | 5 хувь буюу түүнээс бага | 1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2025.01.24-ний өдрийн 2/433 | 2024.01-06 дугаар сар | **100.0** |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | дүнгийн зөрөө | | | дугаар албан бичгээр, ЗГХХГ-т хүргүүлсэн. Үнэлгээний дүн 14.3% байна. 2. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан боловсруулсан. Үнэлгээний дүн .... | | |
| | | | | | хувь байна. Дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, 1а/..... дугаар албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулсан. | | |
| **Зорилт 3. Эрүүл мэндийн яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаа** | | | | | | | |
| 5 | Арга хэмжээ 3.1. Эрүүл мэндийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийх | Үнэлгээний тайлан | Жил бүр үнэлгээ хийж, ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлд танилцуулдаг | Үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлд танилцуулсан байна. | Эрүүл мэндийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, тайлан боловсруулсан. Хяналт-шинжилгээ хувь …… байна. Дүнг Удирдлагын зөвлөлийн 2025.07.....-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. | 2025.06 дугаар сар | **100.0** |
| **Зорилт 4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 4 | Арга хэмжээ 4.2. Эрүүл мэндийн яамны 2024 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Үнэлгээний тайлан | Жил бүр үнэлгээ хийж, тайланг ЗГХХГ-т хүргүүлдэг | Үнэлгээний дүнг хугацаанд нь цахим мэдээллийн санд оруулсан байна. | Эрүүл мэндийн яамны 2024 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан боловсруулсан. Үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Үнэлгээний дүнг 2/1077 дугаар албан бичгээр ЗГХХГ-т | 2025.02-03 дугаар сар | **100.0** |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулсан. ЭМЯ-ны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 62.3 хувь, Яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт 41.7 хувь, Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт 77.1 хувь тус тус байна. | | |
| 5 | Арга хэмжээ 4.3. Эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Үнэлгээний тайлан | Жил бүр үнэлгээ хийж, ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлд танилцуулдаг | Үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлд танилцуулсан байна. | Эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээнд ЭЭХХЗГ, ЭМДЕГ, УХТЭ, СЭМҮТ, АӨСҮТ, НЭМҮТ, ХӨСҮТ, ХСҮТ, ГҮТ, ЦССҮТ, ЭМХТ, Баян-Өлгий, Дархан-Уул, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар, Өмнөговь, Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв зэрэг 24 эрүүл мэндийн байгууллагын Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ 2024 оны жилийн эцсийн байдлаар хийж, тайлан боловсруулсан.<br>Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээний дүн, санал, зөвлөмжийг 8/2075-2096, яамны харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээний дүнг 8/2306-2329 дугээр албан бичгээр байгууллага тус бүрт хүргүүлсэн. | 2025.02-03 дугаар сар | **100.0** |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 6 | Арга хэмжээ 4.4. Үндэсний аудитын газраас эрүүл мэндийн салбарын хэмжээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа, хөтөлбөрт хийгдсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд явцын хяналт тавьж, биелэлтийг хангуулах | Аудитын зөвлөмжийн тоо | Аудитын зөвлөмжийн биелэлтийг ҮАГ-т хүргүүлдэг | Аудитын зөвлөмжийн биелэлтийг ҮАГ-т хүргүүлсэн байна. | Үндэсний аудитын газраас эрүүл мэндийн салбарын хэмжээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа, хөтөлбөрт 2020-2024 онд хийгдсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд явцын хяналт хийж байна. 2020-2024 оны хугацаанд хууль, бодлого, тогтолцоо, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, сан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд ойролцоо 43 гүйцэтгэлийн, нийцлийн, санхүүгийн тайлангийн аудит тус тус хийгдсэн байна.<br>“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн” сэдэвт аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн тайланг 2025.02.12-ны өдрийн 2/798 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. | 2025.01-06 дугаар сар | **100.0** |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажиллах | | | | Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажиллаж, 2025 оны 03 дугаар сараас нарийн бичгийн даргаар ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 6 удаа хуралдсан байна. | 2025.01-06 дугаар сар | **100.0** |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | ТНБД-ын 2024 оны А/56 дугаар тушаал | | | | 2025 онд Ёс зүйн хороо, Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан 2 сургалтад хамрагдсан. Үүнд: Удирдлагын академиас 2025 оны 03 дугаар сарын 11-12-ны өдөр зохион байгуулсан "Ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах" сэдэвт 16 цагийн сургалт, Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалтад 2025 оны 05 дугаар 21-23, 27-ны өдөр тус тус хамрагдаж, гэрчилгээ авсан. | | |
| 2 | Эрүүл мэндийн яамны төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээ хийх ажлын хэсэгт ажиллах<br><br>ТНБД-ын 2024.12.05-ны өдрийн А/132 дугаар тушаал | Үнэлгээний дүн | - | ТАХ-ын гүйцэтгэлийн үнэлгээний дүн гарсан байна. | Эрүүл мэндийн яамны төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээ хийх ажлын хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс ажиллаж байна. | 2025.06 дугаар сар | **100.0** |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Ёс зүйн сургалтад хамрагдах | Гэрчилгээ | - | Сургалтад хамрагдсан байна. | Удирдлагын академиас зохион байгуулсан “Ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах” сэдэвт 16 цагийн сургалтад 2025 оны 03 дугаар сарын 11-12-ны өдөр хамрагдаж, гэрчилгээ (№Z0535) авсан. | 2025.03.11-12 | **100.0** |
| | | | | | Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалтад 2025 оны 05 дугаар 21-23, 27-ны өдөр хамрагдаж, гэрчилгээ (№Z1441) авсан. | 2025.05.21-23 | **100.0** |
| 2. | Арга хэмжээ 2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний сургалтад хамрагдах | Гэрчилгээ | - | Сургалтад хамрагдсан байна. | “Монгол Улсын хөгжлийн бодлогын үнэлгээний чадавхын индекс тогтоох”, “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх арга зүй” сургалтад 2025.05.14, 05.16-ны өдөр тус тус оролцож, гэрчилгээ (№20250163) авсан. | 2025.05.14, 05.16 | **100.0** |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ахлах шинжээч — С.Энхжин /..................../ — 2025.06.09

*(Албан тушаал)* — *(Нэр, гарын үсэг)* — *(Огноо)*